



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ГАЗАР ТАРИАЛАН

Улаанбаатар
2022 он



ГАЗАР ТАРИАЛАН


Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг иргэд, аж ахуйн нэгж, байгууллага 2021 онд 19.2 га талбайд төмс, 95.4 га талбайд хүнсний ногоо тус тус тариалжээ. Нийт 27.6 га хүлэмжийн талбайд ногоо тарьсны 48.2 хувийг өргөст хэмх, 15.6 хувийг улаан лооль, 36.2 хувийг бусад хүнсний ногооны тариалалт эзэлж байна. 2020 онтой харьцуулахад төмс тариалалт 14.4 га талбайгаар, хүнсний ногоо тариалалт 8.2 га талбайгаар буурчээ.

ХҮСНЭГТ 1. 2021 ОНД ТАРИАЛСАН ТАЛБАЙ, га

Төрөл	Тариалсан талбай	Иргэд	Аж ахуйн нэгж
Төмс	19.2	11.5	7.7
Хүнсний ногоо, бүгд	95.4	77.5	17.9
Үүнээс: байцаа	41.3	32.7	8.6
Лууван	5.0	4.9	0.1
Шар манжин	9.0	9.0	-
Улаан манжин	1.8	1.8	0.01
Сонгино	9.2	7.6	1.6
Сармис	1.4	0.4	1.0
Өргөст хэмх	13.3	12.1	1.2
Улаан лооль	4.3	2.6	1.7
Хулуу	1.6	1.1	0.5
Чинжүү	0.4	0.3	0.1
Тарвас	0.1	-	0.1
Амтат гуа	0.2	0.2	-
Бусад	7.8	4.8	3.0
Ногоон тэжээл	3.0	2.0	1.0
Эмийн ургамал	0.003	-	0.003

Тариалсан нийт талбайн 22.3 хувийг аж ахуй нэгж байгууллага, 77.7 хувийг иргэд тариалсан байна. Нийт 19.2 га талбайгаас 203.9 тонн төмс, 95.4 га талбайгаас 1831.2 тонн хүнсний ногоо, 12387.9 тонн өвс, 1098.2 тонн гар тэжээл, 353.6 тонн хужир шүү бэлтгэсэн байна.


ЗУРАГ 1. ТАРИАЛСАН ТАЛБАЙ, га, 2021 он



ЗУРАГ 2. ХУРААСАН ТӨМС, тонн



ЗУРАГ 3. ХУРААСАН ХҮНСНИЙ НОГОО, тонн



ХҮСНЭГТ 2. ХУРААСАН ТӨМС, ХҮНСНИЙ НОГОО, тонн

Үзүүлэлт	2018 он		2019 он		2020 он		2021 он	
	Төмс	Хүнсний ногоо	Төмс	Хүнсний ногоо	Төмс	Хүнсний ногоо	Төмс	Хүнсний ногоо
Нийслэл	1 689.8	5 114.2	1 476.2	4 548.3	1 941.1	4 608.9	1 350.7	3 315.4
Хан-Уул дүүрэг	390.1	2 987.3	324.6	3 096.4	218.9	2 060.7	203.9	1 831.2
Нийслэлийн дүнд эзлэх хувь	23.1	58.4	22.0	68.1	11.3	44.7	15.1	55.2

Нийслэлийн хэмжээнд хураасан нийт төмс, хүнсний ногооны 43.6 хувийг Хан-Уул дүүргийн иргэд, аж ахуйн нэгж хураан авчээ.

Дүүргийн хэмжээнд 2021 онд хураасан нийт ургацын 95.0 хувийг 13-р хороо, 4.5 хувийг 14-р хороо, 0.1 хувийг 12-р хороо, 0.4 хувийг бусад хорооны ургац хураалт тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 3. УРГАЦ ХУРААЛТ, хороогоор, тонн

Хороо	Төмс	Хүнсний ногоо	Бэлтгэсэн өвс	Гар тэжээл	Хужир шүү
Бүгд	203.9	1 831.2	12 387.9	1 098.2	353.6
5-р хороо	0.81	0.35	-	-	-
6-р хороо	0.07	0.30	-	-	-
8-р хороо	0.4	2.4	-	-	-
9-р хороо	0.23	0.52	-	-	-
10-р хороо	0.478	0.24	-	-	-
12-р хороо	0.96	0.78	2353	144	163
13-р хороо	187.1	1746.3	4 433.3	318.6	96.9
14-р хороо	13.01	79.63	5 601.6	635.6	93.7
16-р хороо	0.88	0.7	-	-	-

Танилцуулга бичсэн: Статистикийн хэлтсийн
мэргэжилтэн Ц.Энх-Оюун